



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2019 оны 01 сарын 02 өдөр

Дугаар А/01

Улаанбаатар хот


Нийслэлийн нутаг дэвсгэрт бүх нийтийн их
цэвэрлэгээ зохион байгуулах тухай

Хот тосгоны эрхзүйн байдлын тухай хуулийн 21.3, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан “Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам”-ын 2 дугаар хэсгийн 2.4.1 дэх заалт, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотын нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбай, гэр болон орон сууцны хорооллын цэвэрлэгээ үйлчилгээг сайжруулах, иргэдийн ая тухтай ажиллаж, амьдрах таатай орчин, нөхцлийг бүрдүүлэх зорилгоор зохион байгуулагдах бүх нийтийн их цэвэрлэгээний ажлын хуваарийг хавсралт ёсоор баталсугай.


2. Дүүргийн нутаг дэвсгэрт их цэвэрлэгээг зохион байгуулах ажлын хэсэг байгуулж, удирдамж, хуваарь, төлөвлөгөөг батлан хэрэгжилтэд хяналт тавих, харьяа газар болон аж ахуйн нэгж байгууллага, иргэдийг цэвэрлэгээнд бүрэн хамруулж оролцуулах, үр дүнг тайлагнаж ажиллахыг дүүргүүдийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж бүх нийтийн их цэвэрлэгээний тайлан, дүн мэдээг тухай бүр танилцуулж ажиллахыг Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтэс /Г.Ууганбаяр/-т даалгасугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  Т.ГАНТӨМӨР



Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2019 оны 01 сарын 02-дрийн А/01
тушаалын хавсралт



НИИСЛЭЛИЙН ХЭМЖЭЭНД 2019 ОНД БҮХ НИЙТИЙН ИХ
ЦЭВЭРЛЭГЭЭ ЗОХИОН БАЙГУУЛАХ ХУВААРЬ

№	Цэвэрлэгээ зохион байгуулах хугацаа	Байршил	Хариуцан зохион байгуулах мэргэжилтэн	Албан тушаал
1	2019 оны 01-р сарын 26,27	9-н дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд /нийслэлийн агентлагууд/	З.Мөнгөнзул	ТХХУХ-ийн мэргэжилтэн
2	2019 оны 04-р сарын 27	9-н дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд /нийслэлийн агентлагууд/ "Их цэвэрлэгээний 90 минут"	С.Аригуун	ТХХУХ-ийн Ахлах мэргэжилтэн
3	2019 оны 05-р сарын 18	Зуслан, ногоон бүсийн цэвэрлэгээ	Т.Энх-Амгалан	ТХХУХ-ийн мэргэжилтэн
4	2019 оны 06-р сарын 29	Үндэсний их баяр наадам угтсан цэвэрлэгээ 9-н дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд /нийслэлийн агентлагууд/	Б.Мөнхбаяр	ТХХУХ-ийн мэргэжилтэн
5	2019 оны 10-р сарын 19	9-н дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд	З.Мөнгөнзул	ТХХУХ-ийн мэргэжилтэн
6	2019 оны 12-р сарын 07	9-н дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд	Б.Мөнхбаяр	ТХХУХ-ийн мэргэжилтэн